



МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧИН, ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧИД ТОДОРЛОО

Сар шинийн өмнөхөн Монгол улс аварга малчин, тэргүүний тариаланчаа шалгаруулдаг уламжлалтай. Засгийн газрын шийдвэрээр **“МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧИН”** цолоор:

1. Увс аймгийн Өлгий сумын Чаргат багийн малчин Цэвээний Доржсүрэн
2. Бөхмөрөн сумын Хар-Алтан багийн малчин Чойндонгийн Батжаргал
3. Хяргас сумын Бугат багийн малчин Бужгарын Баяртогтох
4. Тэс сумын Нуур багийн малчин Нинжийн Цогтоо
5. Баруунтуруун сумын Зүүнтуруун багийн малчин Шаравын Даваадорж нар

“УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ” - аар



гардуулан өгч баяр хүргэлээ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД УВС АЙМАГТ АЖИЛЛАЛАА



Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Зам тээврийн хөгжлийн дэд сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Эрүүл мэндийн дэд сайд болон албаны бусад хүмүүс хүрэлцэн ирсэн юм.

Тэрбээр аймгийн дулааны 2-р станц, НЭ-ийн төрөх тасгийн үйл

ажиллагаатай танилцаж, улмаар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил, хөтөлбөр-5” төслийн хүрээнд Увс аймгийн цусны салбар төвийн барилга, хөрөнгө

оруулалтын ажлыг хүлээн авах нээлтэнд оролцсоны дараа Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбал агсаны хөшөөнд хүндэтгэл үзүүлсэн бөгөөд үүний дараа аймгийн иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийж, 2016 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулж, чөлөөт ярилцлага өрнүүлээ.



МУ-ЫН ШАДАР САЙД, УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА У.ХҮРЭЛСҮХЭЭР АХЛУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ УВС АЙМАГТ АЖИЛЛАЛАА



МУ-ын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцах зорилгоор баруун таван аймагт

ажиллаж байна. 2-р сарын 19, 20-ны өдрүүдэд Увс аймгийн Бөхмөрөн, Түргэн, Улаангом сумдад ажиллаа.

Өвөжилт хүндрээд байгаа ба хүндрэх төлөвтэй байгаа аймаг, сумдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх, хямдруулж олгох, малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, машин техник, эм, био бэлдмэл, шатахуун, тээврийн зардалд зориулж МУ-ын ЗГ-аас 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн гаргахаар

шийдвэрлэсний хэрэгжилтийг хангуулах, өвөлжилт хүндрээд байгаа сумд руу тусламжийн цувааг гаргах, бодит байдалтай танилцах зорилготой тус ажлын хэсэгт ОБЕГ-ын дарга,



Бригадын генерал Т.Бадрал, ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын дарга, ахмад Я.Гантөмөр, Шадар сайдын зөвлөх, хурандаа Л.Алтангэрэл, зөвлөх Л.Сайнаа, А.Үйлстөгөлдөр болон Улсын онцгой комиссын шуурхай ажилласан бөгөөд 02.20-ны шөнө 01цагт Түргэн суманд ажлаад Улаангом сумын 1-р баг буюу Чандманий замын дээд талын хачир дэлгэж зам давж, айл өрхүүд усанд автаж болзошгүй байгаатай газар дээр нь танилцаж, 03 цагт аймгийн онцгой комиссын шуурхай хурал зарлан хуралдууллаа. Хуралд Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга Д.Батсайхан, аймгийн ОБГ-ын дарга Б.Баттулга нар цаг үеийн нөхцөл байдал, өвөлжилтийн талаар мэдээлэл хийсэн юм.

АЙМГИЙН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



XVII жарны гал тахиа жилийн сар шинийн босгон дээр аймгийн Иргэдийн Төлөөлөгдийн Хурлын дарга Э.Насанбат ажлын албанд олон жил ажиллан гавъяаныхаа амралтанд суугаа ахмад буурлуудаа хүлээн авч

хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа.



**АЙМГИЙН САЙН МАЛЧИД БАТЛАМЖАА ГАРДАН
АВЛАА**



Жил бүрийн сар шинийн босгон дээр аймгийн сайн малчны болзлын шалгуур үзүүлэлтийг хангаж, иргэний үндсэн болон журамт

үүргээ биелүүлж, мал сүргээ өсгөх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, нийгмийн харуцлагаа ухамсарлан сайн үйлс бүтээсэн малчдаа тодруулан "Аймгийн сайн малчин"-аар шалгаруулаад уламжлалтай билээ.

XVII жарны Алтан унжлагат"хэмээх гал Тахиа жил "Аймгийн сайн малчин", "Аймгийн алдарт уяач"-цолоор шагнагдсан малчдад аймаг, орон нутгийн удирдлагууд цол, тэмдэг, батламжийг нь хүндэтгэлтэйгээр гардуулан өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Б.Бат-ерөөлт нар Сагил сумын Баянзүрх багийн малчин С.Баянмөнх, Өндөрмод багийн малчин Л.Сандаг, Боршоо багийн малчин Б.Дамбадорж нарын гэр бүлд "Аймгийн сайн малчны" тэмдэг, батламжийг гардуулан өгч баяр хүргэлээ.

ТӨРИЙН ДЭЭД ОДОН, МЕДАЛЬ ГАРДУУЛАВ

Төр захиргаа, боловсрол, эрүүл мэнд, төрийн тусгай байгууллага, биеийн тамир спорт, байгаль орчин, авто тээвэр, хөдөө аж ахуй, хувийн хэвшил,



банк санхүү болон бусад салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн тогтвортой, өндөр амжилт гарган аймаг орон нутгийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан нэр бүхий хүмүүсийн хөдөлмөрийг төр засаг өндөрөөр үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 28 дугаар зарлигаар төрийн дээд одон медалиар шагнасныг аймгийн удирдлагууд шагналыг нь гардуулж баяр хүргэлээ.

Мөн үеэр Увс аймгийн 2016 оны салбар салбарын шилдэг, тэргүүний ажилтан, албан хаагчид, сурагчид, тамирчид, тэргүүний байгууллага, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулж шагнаж урамшууллаа.

- "2016 ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА"-аар
1. "Тэргүүний төрийн үйлчилгээний багууллага"-аар Түргэн сумын Эрүүл мэндийн төв
 2. "Тэргүүний төрийн бус байгууллага"-аар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны Увс аймаг дахь салбар зөвлөл
 3. "Тэргүүний худалдаа үйлчилгээний байгууллага"-аар "Мөнхийн чанар" ХХК
 4. "Тэргүүний үйлдвэрлэгч байгууллага"-аар "Дөрвөн булаг" ХХК
 5. "Тэргүүний татвар төлөгч байгууллага"-аар "Цагаан хөшөө трейд" ХХК тус тус шалгарч шагналаа гардан авлаа.

ХОВД СУМ:

Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2017 оны 02 сарын 06-08 хооронд ИТХ-ын дарга Халиунбулаг багт, ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ачит багт ажиллаж ИТХ-аас гарсан шийдвэрийг сурталчлах, сумын хөгжлийн хөтөлбөрт тусгах санал авах,иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд 2 багийн 90



гаруй өрхийн иргэдтэй уулзаж санал хүсэлтийн хүлээн авлаа.

ДАВСТ СУМ:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа хуралдуулж, нийт 7 тогтоол гаргасан байна. Хуралдаанаар тэргүүний төлөөлөгч шалгаруулах болзлыг шинэчлэх, Хүнс ХАА-н талаар баримтлах бодлого /2017-2025/, Төрийн одон медалиар шагнагдах хүмүүсийн талаархи саналыг хэлэлцэн 2 хүнийг "Алтан гадас" одонд, 4 хүнийг "Хөдөлмөрийн хүндэт" медалиар шагнуулахаар тодорхойлж, саналыг уламжлах, Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ажиллах хэсэг, нутаг дэвсгэр, төвийг тогтоох, 7 хүнийг "Алдарт эх" хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар саналыг хэлэлцэн уламжлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэв.

Мөн ГХУСЗ-ийн хурлыг 2017 оны 2 дугаар сарын 09-нд хуралдуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрхэн зохион байгуулах талаар хэлэлцэн санал бодлоо солилцов. Үүний дагуу дараахи ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: Сумын ГХУСАЗСЗ нь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017.01.25-ны 07 тоот хууль сурталчлах ажлыг зохион байгуулах тухай тогтоол, ГХУСАЗСЗ-ийн ажлын 2017 оны төлөвлөгөө, "Мэдээллийн цаг" хөтөлбөрөөр иргэдэд хууль сурталчлах график зэрэгт тусгагдсаны дагуу 2 дугаар сард Архидан согуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчиллаа.

ЗАВХАН СУМ:

**УВС АЙМГИЙН ЗАВХАН СУМЫН АЙРАГ НУУР
БАГИЙН МАЛЧИН Д.ДАМДИНСҮРЭН "АЛТАН
БОТГОНЫ ЭЗЭН" БОЛЛОО**

ХХААЯ, МҮОНРТ-ийн хамтарсан шийдвэрээр Алтан ботгоны эзэн" болсон Увс аймгийн Завхан сумын Айрагнуур багийн малчин Дүхэржавын Дамдинсүрэнд аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, ТЗУХ-ийн дарга У.Ганзориг, сумын удирдлагууд шагналыг гардуулж, баяр хүргэлээ.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал